



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/31

Батноров сум

┌
Үндсэн хөрөнгөд бүртгэх тухай
└


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тавдугаар хуралдааны 2025 оны 12 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны A/226 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын эрүүл мэндийн төвөөс Засаг даргын Тамгын газарт шилжин ирж буй 47-30 ХЭА улсын дугаартай, Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 44.990.000 (Дөчин дөрөв сая есөн зуун ерэн мянган) төгрөгийн балансын үнэтэй, 21.870.138.9 (Хорин нэгэн сая найман зуун далан мянга нэг зуун гучин найм төгрөг есөн) мөнгөний хуримтлагдсан элэгдэлтэй, 23.119.861.15 (Хорин гурван сая нэг зуун арван есөн мянга найман зуун жаран нэг төгрөг арван таван) мөнгөний үлдэх өртөг бүхий Пургон авто машиныг сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэсүгэй.

2. Дээрх хөрөнгийг байгууллагын үндсэн хөрөнгө, өмч бүртгэлд тусгахыг Санхүү албаны нягтлан бодогч (Б.Энхжаргал), нярав (Г.Пүрэвсүрэн) нарт үүрэг болгосугай.

3. Авто машины ашиглалт, хамгаалалт засвар үйлчилгээг бүрэн хариуцахыг Засаг даргын Тамгын газрын жолооч (М.Мөнхбат)-д даалгасугай.

ДАРГА



А.БОРЧУЛУУН

230425108